

Сумын “Хог тээвэрлэх автомашин худалдан авах” ажлын бараа нийлүүлэх үнийн санал авах тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дүгнэлт

2020.03.06

Шивээговь сум

Шивээговь сумын 2020 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Хог тээвэрлэх автомашин худалдан авах” ГСАШГСЗДТГ/202012006-дугаар ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн дагуу цахим хэлбэрээр зарлаж, 27, 28-р зүйл болон Сангийн сайдын 2012 оны 09-р сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Цахим тендер шалгаруулалтад “Барга хайрхан” ХХК, “Альянстрейд” ХХК, “Нутгийн буян групп” ХХК, “Харвайн толгой” ХХК, “Бадрангуй орших” ХХК, “Ариунбилгүүн” ХХК, нийт 6 компани тендер ирүүлсэн ба дараахь байдлаар дүгнэж байна. Үүнд:

1. **“Барга хайрхан” ХХК**-ийн ирүүлсэн тендер нь:

1) Захиалагчийн баталсан Тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 21.1-д заасан **“Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа: Тендер нээсэн өдрөөс хойш 58 хоногийг дуустал”** гэж заасан шаардлагыг хангахгүй буюу тендерийн баталгааны хүчинтэй хугацаа хүрэхгүй байна.

2) Захиалагчийн баталсан Тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 18.1 (б), 18.1 (г)-д заасан санхүүгийн тайлан болон ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл дутуу ирүүлсэн буюу 2017 оны санхүүгийн тайлан, 2017, 2018 оны ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл ирүүлээгүй байна.

3) Захиалагчийн баталсан Тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 18.2 (а)-д **“Сүүлийн 3 жилийн борлуулалт нь тус бүр санал болгож буй үнийн дүнтэй тэнцүү буюу багагүй байх”** гэж заасан шалгуур үзүүлэлтэд “Барга хайрхан” ХХК-ийн 2018 оны санхүүгийн борлуулалтын орлого бага буюу шаардлага хангахгүй тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.5, 27 дугаар зүйлийн 27.4, Сангийн сайдын 2012 оны 09-р сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын 6.4 дэх заалтыг үндэслэн “Барга хайрхан” ХХК-ийн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж уг тендерээс татгалзаж байна.

2. **“Альянстрейд” ХХК**-ийн ирүүлсэн тендер нь:

1) Захиалагчийн баталсан Тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 21.1-д заасан **“Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа: Тендер нээсэн өдрөөс хойш 58 хоногийг дуустал”** гэж заасан нь шаардлагыг хангахгүй буюу тендерийн баталгааны хүчинтэй хугацаа хүрэхгүй байна.

2) Захиалагчийн баталсан Тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 18.1 (г)-д заасан ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл дутуу ирүүлсэн буюу 2018 оны ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл нь шаардлагыг хангахгүй байгаа тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

авах тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.5, 27 дугаар зүйлийн 27.4, Сангийн сайдын 2012 оны 09-р сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Тендерийн үнэлгээний заавар"-ын 6.4 дэх заалтыг үндэслэн "Альянстрейд" ХХК-ийн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж уг тендерээс татгалзаж байна.

3. "Нутгийн буян" ХХК-ийн ирүүлсэн тендер нь:

1) Захиалагчийн баталсан Тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 18.1 (б)-д "Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 оны санхүүгийн тайлан, 2017, 2018, 2019 оны аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх" гэж заасан шаардлагыг хангаагүй буюу 2019 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтгүй ирүүлсэн;

2) Захиалагчийн баталсан Тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 18.2 (г)-д "Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 70 сая төгрөг. **Арилжааны банкны судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлэх** /Банк бус санхүүгийн байгууллагын тодорхойлолт болон банкны зээлийг судалж үзэж олгох тухай тодорхойлолтыг хүчингүйд тооцно./" гэж заасан бөгөөд ирүүлсэн тендерийн хувьд дээрх шаардлагыг хангах нотолгоо болохгүй тул "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтыг үндэслэн "Нутгийн буян групп" ХХК-ийн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж уг тендерээс татгалзаж байна.

4. "Ариунбилгүүн" ХХК-ийн ирүүлсэн тендер захиалагчийн баталсан тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 12.1 (ё)-д заагдсан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахгүй буюу Татварын байгууллагын өр төлбөрийн үлдэгдэлтэй тодорхойлолт ирүүлсэн тул "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, Сангийн сайдын 2012 оны 09-р сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Тендерийн үнэлгээний заавар"-ын 6.1 дэх заалтыг үндэслэн "Ариунбилгүүн" ХХК-ийн ирүүлсэн тендерийг Тендерт оролцогчийн ерөнхий нөхцөлийг хангаагүй гэж үзэж татгалзаж байна.

5. "Харвайн толгой" ХХК болон "Бадрангуй орших" ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзэж шаардлагад нийцсэн гэж үзсэн тул "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3, 28.7.4 дэх заалтын дагуу "Харвайн толгой" ХХК-ийн 66980000 /Жаран зургаан сая есөн зуун ерэн мянга/ төгрөгийн үнийн санал, "Бадрангуй орших" ХХК-ийн 68000000 /Жаран найман сая/ төгрөгийн үнийн саналыг харьцуулан эрэмбэлж, үнэлгээний хорооны гишүүдийн 100%-ийн саналаар хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Харвайн толгой" ХХК-ийн ирүүлсэн тендерийг "Хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзэж шийдвэрлэсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА  Ж.БАТМӨНХ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  З.БААСАНДАЛАЙ

ГИШҮҮД:  А.НАНДИНЦЭЦЭГ

 Д.ДАРХИЖАВ

 Ш.БУЯННЭМЭХ